



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 28 өдөр

Дугаар A/1/8

Арвайхээр

Батлан хамгаалахын хууль тогтоомж,
шиидвэрийн хэрэгжилтэд шалган туслах
ажил явуулах тухай

Монгол улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 18 дугаар зүйлийн 18.1.1 заалт, Засгийн газрын 2004 оны 66 дугаар тогтооолоор батлагдсан “Аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штабын дүрэм”-ийн 3.1, 9.4 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батлан хамгаалах салбарын хууль тогтоомж, шиидвэрийг хэрэгжилтэд шалган туслах ажил явуулах комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Байгууллага, аж ахуйн нэгжүүдэд Батлан хамгаалах тухай хууль, Цэргийн албаны тухай хууль, Дайчилгааны тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хууль тогтоомжийн биелэлт, хэрэгжилтэд шалган туслах ажлыг чанартай зохион байгуулж, дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэллэлцүүлэхийг Цэргийн штабын дарга (хурандаа М.Дэлгэрсайхан)-д үүрэг болгосугай.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г. ГАНБОЛД

011100105

Аймгийн Засаг даргын 2019..... оны .01.
дугаар сарын 28.ны өдрийн 11 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

ШАЛГАН ТУСЛАХ АЖИЛ ЯВУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: М.Дэлгэрсайхан-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа

Нарийн бичгийн дарга: Ч.Адъяа- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер, хошууч

Гишүүдэд: А.Отгонцэцэг-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Б.Өлзийбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер, хошууч

Р.Цэрэндэжид-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн ахлах мэргэжилтэн, Улсын дайчилгааны мэргэжилтэн

-оOo-